



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа
эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Эрдэнэбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 8. дугаар сарын 29-ний
өдрийн 274 дүгээр тогтоолын хавсралт



“МОНРЕ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчийн нэр /Регистрийн дугаар/	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Р.Туяацэцэг /РД: УУ56071002/	2,096,008	2,096,008,000	59.89%	559,553	559,553,000		2,655,561	2,655,561,000	53.11%
2	У.Сийлэн /РД: ЧК80090709/	1,403,992	1,403,992,000	40.11%	364,874	364,874,000		1,768,866	1,768,866,000	35.38%
3	П.Эрдэнэбаатар /РД: ЧК87020712/				575,573	575,573,000		575,573	575,573,000	11.51%
	Нийт	3,500,000	3,500,000,000	100%	1,500,000	1,500,000,000		5,000,000	5,000,000,000	100%